# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 18 (155)

**Монгол Улсын Хууль:**

- *Монголын улаан загалмай нийгэмлэгийн эрх зүйн байдлын тухай*
- *Химийн хорт бодисоос хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*

**Монгол Улсын Засгийн газрын тогтоол:**

- *2000 оны төвлөрсөн төсвийг биелүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай*
- *Баруун аймгуудын талаар авах зарим арга хэмжээний тухай*

**Улсын Их Хурлын Тамгын газар**

**Улаанбаатар хот**
**2000 он**

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2000 оны тавдугаар сарын 17 №18 (155)

## Гарчиг

### Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

| | | | |
|---|---|---|---|
| 200. | Монголын улаан загалмай нийгэмлэгийн эрх зүйн байдлын тухай (2000-4-28-ны хууль) | | 376 |
| 201. | Химийн хорт бодисоос хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2000-4-28-ны хууль) | | 378 |

### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

| | | | |
|---|---|---|---|
| 202. | Монгол банкны худалдан авах алт болон Монгол банкнаас худалдах алт, мөнгөний хэмжээ тогтоох тухай | Дугаар 38 | 378 |

### Гурав. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

| | | | |
|---|---|---|---|
| 203. | Н. Володя, Ц. Ганбат нарыг шүүгчийн албан тушаалаас огцруулах тухай | Дугаар 48 | 379 |
| 204. | Лувсанцэрэнгийн Галмандахад Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай | Дугаар 49 | 379 |
| 205. | Цэндхүүгийн Хандад Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай | Дугаар 50 | 379 |
| 206. | Цэндсүрэнгийн Энхманлайд Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээх тухай | Дугаар 51 | 379 |
| 207. | Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай | Дугаар 52 | 380 |
| 208. | Очирбатын Нямдоржийг "Шударга журам" медалиар шагнах тухай | Дугаар 53 | 382 |
| 209. | Жадамбаагийн Мөнхзулыг "Шударга журам" медалиар шагнах тухай | Дугаар 54 | 382 |

### Дөрөв. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

| | | | |
|---|---|---|---|
| 210. | Тогтоолын заалтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Дугаар 38 | 383 |
| 211. | 2000 оны төвлөрсөн төсвийг биелүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай | Дугаар 39 | 383 |
| 212. | Тогтоолыг өөрчлөн найруулах тухай | Дугаар 40 | 390 |
| 213. | Баруун аймгуудын талаар авах зарим арга хэмжээний тухай | Дугаар 41 | 390 |

### Тав. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 214. | Шүүхийн тухай хууль, ИХШХШ хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын хуулиудын холбогдох заалтууд, эдгээрийг хэрэгжүүлэхээр гарсан Ерөнхийлөгчийн зарлигууд Монгол Улсын Үндсэн хуулийн зарим заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцсэн тухай | Дугаар 02 | 391 |

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2000 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр

Улаанбаатар хот

## МОНГОЛЫН УЛААН ЗАГАЛМАЙ НИЙГЭМЛЭГИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ

### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

#### 1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Монголын улаан загалмай нийгэмлэг /цаашид "МУЗН" гэх/-ийн эрх зүйн байдлыг тодорхойлж, зохион байгуулалт, бүрэн эрх, түүний баталгаа, төрөөс МУЗН-т дэмжлэг үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

#### 2 дугаар зүйл.МУЗН-ийн эрх зүйн байдлын тухай хууль тогтоомж

2.1.МУЗН-ийн эрх зүйн байдлын тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль[1] Төрийн бус байгууллагын тухай[2], Донорын тухай хууль[3], энэ хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

#### 3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёо

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1. "хөдөлгөөн" гэж олон улсын улаан загалмай /улаан хавирган сар/ хөдөлгөөнийг;

3.1.2."хөдөлгөөний үндсэн зарчмууд" гэж энэрэнгүй, шударга, төвийг сахих, бие даах, сайн дурын, нэгдмэл, түгээмэл байх олон улсын улаан загалмай /улаан хавирган сар/ хөдөлгөөний үндсэн зарчмуудыг;

3.1.3."Женевийн конвенц" гэж 1949 оны 8 дугаар сарын 12-ны өдөр баталсан "Дайтаж байгаа армийн шархадсан ба өвчтэй цэргийг асран хамгаалах тухай", "Тэнгисийн зэвсэгт хүчний шархдагсад, өвчтөн, хөлөг онгоцны сүйрэлд нэрвэгдэгсдийг асран хамгаалах тухай", "Дайнд олзлогдогсодтой харьцах тухай", "Дайны үед энгийн хүн амыг хамгаалах тухай" Женевийн конвенцуудыг;

3.1.4."Нэмэлт протоколууд" гэж 1977 оны 6 дугаар сарын 8-ны өдөр баталсан олон улсын зэвсэгт мөргөлдөөнд хэлмэгдэгсдийг хамгаалахтай холбогдсон Нэмэлт, олон улсын бус чанартай зэвсэгт мөргөлдөөнд хэлмэгдэгсдийг хамгаалах тухай Женевийн конвенцийн Нэмэлт протоколуудыг;

3.1.5."хөдөлгөөний дүрэм" гэж олон улсын улаан загалмай /улаан хавирган сар/ нийгэмлэгүүдийн холбооны бага хурлаар батлагдсан олон улсын улаан загалмай /улаан хавирган сар/ нийгэмлэгийн хөдөлгөөний дүрмийг;

3.1.6."холбооны үндсэн дүрэм" гэж олон улсын улаан загалмай /улаан хавирган сар/ нийгэмлэгүүдийн холбооны ерөнхий ассамблейн чуулганаар батлагдсан олон улсын улаан загалмай /улаан хавирган сар/ нийгэмлэгүүдийн холбооны үндсэн дүрмийг.

### ХОЁРДУГААР БҮЛЭГ. МУЗН-ИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ

#### 4 дүгээр зүйл.МУЗН байгуулагдах онцлог

4.1.Олон улсын улаан загалмай /улаан хавирган сар/ хөдөлгөөний дүрэм, үндсэн зарчимд нийцүүлэн Монгол Улсад үндэсний улаан Загалмайн нэг нийгэмлэг байгуулагдаж, үйл ажиллагаагаа Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд явуулна.

#### 5 дугаар зүйл.Монголын улаан загалмай нийгэмлэг

5.1.МУЗН нь иргэдээс хөдөлгөөний дүрэм, үндсэн зарчмуудыг зөвшөөрч, тэдгээрийг болон Женевийн конвенц, Нэмэлт протоколуудын зарчим, хэм хэмжээ, үзэл санааг хэрэгжүүлэх, төрийн хүмүүнлэгийн бодлогод дэмжлэг үзүүлэх зорилгоор сайн дурын үндсэн дээр байгуулагдан өөрийгөө удирдах ёсны дагуу үйл ажиллагаа явуулдаг нийгэмд үйлчилдэг төрийн бус, хүмүүнлэгийн байгууллага мөн.

5.2.МУЗН-ийн эрх зүйн байдлыг энэ хуулиар, нийгэмлэг байгуулах, бүртгэх, татан буулгах, түүний үйл ажиллагаа, өмч, санхүүгийн харилцааг Төрийн бус байгууллагын тухай хуулиар, МУЗН-ийн дотоод зохион байгуулалттай холбоотой асуудлыг нийгэмлэгийн дүрмээр зохицуулна.

#### 6 дугаар зүйл.МУЗН-ийн зорилго, чиг үүрэг

6.1.МУЗН-ийн зорилго нь хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалах, хүмүүнлэг ёсыг хангахад дэмжлэг, туслалцаа үзүүлэх, хүмүүсийн хоорондын харилцан ойлголцол, нөхөрлөл, хамтын ажиллагааг нь дэмжих, энх тайвныг бэхжүүлэх үйлсэд хувь нэмэр оруулахад оршино.

6.2.МУЗН-ийн чиг үүргийг энэ хуулийн 7.1.-д заасан МУЗН-ийн үйл ажиллагааны үндсэн зарчимд нийцүүлэн МУЗН-ийн дүрмээр тодорхойлно.

#### 7 дугаар зүйл.МУЗН-ийн үйл ажиллагааны үндсэн зарчим

7.1.МУЗН үйл ажиллагаандаа олон улсын улаан загалмай /улаан хавирган сар/ хөдөлгөөний дүрэм, хөдөлгөөний үндсэн зарчмууд, холбооны үндсэн дүрэм болон ил тод байх, хууль дээдлэх зарчмыг удирдлага болгоно.

---

[1] Үндсэн хууль-"Төрийн мэдээлэл"-ийн 1992 оны 1 дугээрт нийтлэгдсэн.

[2] Төрийн бус байгууллагын тухай хууль "Ардын эрх" сонины 1997 оны 2 дугаар сарын 26-ны өдрийн 41, "Төрийн мэдээлэл"-ийн 1997 оны 3 дугаарт нийтлэгдсэн.

[3] Донорын тухай хууль "Төрийн мэдээлэл"-ийн 2000 оны 6 дугаарт нийтлэгдсэн.

### 8 дугаар зүйл.МУЗН-ийн бие даасан байдал

8.1.МУЗН нь хөдөлгөөний дүрэм, холбооны үндсэн дүрэм, Женевийн конвенц, Нэмэлт протоколуудын дагуу үйл ажиллагаагаа төрөөс хараат бус, өөрийгөө удирдах ёсны зарчмыг баримтлан явуулна.

8.2.Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, тэдгээрийн албан тушаалтан, иргэн МУЗН-ийн хүмүүнлэгийн үйл ажиллагаанд саад учруулах, хөдөлгөөний болон холбооны үндсэн дүрмийн зарчимд харшилсан аливаа үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

### 9 дүгээр зүйл.МУЗН-ийн гишүүн, ажилтны ёс зүй

9.1.МУЗН-ийн гишүүн, ажилтны ёс зүйн хэм хэмжээг олон улсын эрх зүйн холбогдох хэм хэмжээ, МУЗН-ийн дүрмээр зохицуулна.

### 10 дугаар зүйл. Төрөөс МУЗН-ийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх

10.1.Монгол Улсын Засгийн газрын тухай[1] хуулийн 19 дүгээр зүйлд заасны дагуу Засгийн газар Женевийн конвенцийн хамаарах хүрээнд дайнд нэрвэгдэгсдэд туслах, зэвсэгт мөргөлдөөн үүссэн нөхцөлд хэлмэгдэгсдэд болон байгалийн гамшиг, гэнэтийн осол, сүйрэл, нийтийг хамарсан гоц аюулт халдварт өвчинд нэрвэгдэгсдэд яаралтай тусламж, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх бэлтгэл сургалт зохион байгуулах, эсхүл хүмүүнлэгийн бусад арга хэмжээг хэрэгжүүлэх талаар мэдээлэл, сурталчилгаа хийхтэй холбогдсон зардлыг МУЗН-тэй жил бүр гэрээ байгуулах замаар улсын төсөвт тусгаж санхүүжүүлнэ.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ.
## МУЗН-ИЙН НЭР, БЭЛГЭ ТЭМДЭГ ХЭРЭГЛЭХ ЭРХ

### 11 дүгээр зүйл."Улаан загалмай" нэрийг хэрэглэх эрх

11.1."Улаан Загалмай" гэсэн нэрийг Монгол Улсын нутаг дэвсгэрт зөвхөн МУЗН хэрэглэх эрхтэй.

### 12 дугаар зүйл."Улаан загалмай" бэлгэ тэмдгийг хэрэглэх эрх

12.1.Монгол Улсын нутаг дэвсгэрт "Улаан загалмай" бэлгэ тэмдгийг хөдөлгөөний эрх бүхий байгууллагаас баталсан журмын дагуу өөрийн бэлгэдэл болгон хэрэглэх эрхийг МУЗН эдэлнэ.

12.2.Монгол Улсын нутаг дэвсгэрт "Улаан загалмай" бэлгэ тэмдгийг өөрийн далбаанд хэрэглэх эрхийг МУЗН эдэлнэ.

### 13 дугаар зүйл."Улаан загалмай" нэр, бэлгэ тэмдгийг хэрэглэхийг хориглох

13.1."Улаан загалмай" нэр, бэлгэ тэмдгийг энэ хуульд зааснаас бусад тохиолдолд иргэн, хуулийн этгээд хууль бусаар хэрэглэх, тэдгээрийг ямар нэг хэлбэрээр дууриалган үйлдэж ашиглахыг хориглоно.

### 14 дүгээр зүйл."Улаан загалмай" нэр, бэлгэ тэмдгийг МУЗН-ийн болон бусад үйл ажиллагаанд хэрэглэх

14.1.МУЗН нь дайн, олон улсын болон олон улсын бус зэвсэгт мөргөлдөөний үед шархдагсад, өвчтөн, олзлогдогсод, хэлмэгдэгсэд, аюул осол, сүйрэлд нэрвэгдэгсэд, энгийн иргэдэд Женевийн конвенц, Нэмэлт протоколуудын дагуу хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, тэдгээртэй адилтгах бусад төрлийн үйл ажиллагаа явуулахдаа тусламж шаардагдаж байгаа хүмүүс болон тусламж үзүүлэгчдийг хамгаалах зорилгоор "Улаан загалмай" нэр, бэлгэ тэмдгийг хэрэглэнэ.

14.2.МУЗН нь байгалийн гамшиг, гэнэтийн осол, сүйрэл тохиолдсон, нийтийг хамарсан гоц аюулт халдварт өвчин гарсан үед хөдөлгөөний үндсэн зарчмуудад нийцсэн үйл ажиллагаа явуулахдаа "Улаан загалмай" нэр, бэлгэ тэмдгийг ялгах тэмдгийн зориулалтаар хэрэглэнэ.

14.3. МУЗН-ийн төв, орон нутгийн байгууллагууд өөрийн байрлаж байгаа, эсхүл хүмүүнлэгийн үйл ажиллагаа явуулж байгаа байшин барилга, тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжид "Улаан загалмай" нэр, бэлгэ тэмдэг хэрэглэнэ.

14.4.Тайван цагт шархадсан хүн, өвчтөнд эмнэлгийн төлбөргүй тусламж, үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн байгууллага, түүний тээврийн хэрэгсэлд "Улаан загалмай" бэлгэ тэмдэг хэрэглэх зөвшөөрлийг МУЗН-ийн удирдах байгууллага олгож болно.

### 15 дугаар зүйл. Баталгаат тэмдэг хэрэглэх

15.1.МУЗН-ийн төв, орон нутгийн байгууллага нь олон улсын байгууллага, хуулийн этгээд, иргэдээс тус нийгэмлэгийн нэр дээр ирүүлсэн хандив, тусламжийн бараанд "МУЗН" гэсэн баталгаат тэмдэг тавьж, төлбөргүй олгоно.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ.
## БУСАД ЗҮЙЛ

### 16 дугаар зүйл.МУЗН-ийн эрх зүйн байдлын тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

16.1.МУЗН-ийн эрх зүйн байдлын тухай хууль тогтоомж зөрчсөн иргэн,аж ахуйн нэгж, байгууллага хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээнэ.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА** **Р.ГОНЧИГДОРЖ**

[1] Засгийн газрын тухай хууль "Ардын эрх" сонины 1993 оны 78, "Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 1993 оны 3 дугаарт тус тус нийтлэгдсэн

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**2000 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр** **Улаанбаатар хот**

### ХИМИЙН ХОРТ БОДИСООС ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл**

Химийн хорт бодисоос хамгаалах тухай хуульд дор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

"1/ 2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

2/ 4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг:

4.Химийн зэвсгийн талаархи Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээг хэрэгжүүлэх, батлан хамгаалах салбарт ашигладаг химийн хорт бодисын холбогдолтой үйл ажиллагааг батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага эрхэлж, тайлан мэдээг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

3/ 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 10 дахь заалт:

10/ Монгол Улсад хэрэглэхийг хязгаарласан, хориглосон химийн хорт бодисын жагсаалтыг боловсруулж баталгаажуулах."

**2 дугаар зүйл**

Химийн хорт бодисоос хамгаалах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1, 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "амьтанд" гэсний дараа "аюултай,", 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "чанараар нь" гэсний дараа "онцгой тэсрэмтгий, тэсрэмтгий, онцгой исэлдүүлэгч, исэлдүүлэгч, онцгой шатамхай, шатамхай, онцгой идэмхий, идэмхий, онцгой цочроомтгой, цочроомтгой", 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "байгууллага" гэсний дараа "эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран", 7 дугаар зүйлийн 2 дахь заалт, 13 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "хортой" гэсний өмнө "тэсрэмтгий, исэлдүүлэгч, шатамхай, идэмхий, цочроомтгой", 7 дугаар зүйлийн 2 дахь заалтын "импортлоход" гэсний дараа "салбар зөвлөлөөс дүгнэлт гаргуулж", мөн зүйлийн 3 дахь заалт, 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 4 дэх заалт, 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, 13 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтын "онцгой хортой" гэсний өмнө "онцгой тэсрэмтгий, онцгой исэлдүүлэгч, онцгой шатамхай, онцгой идэмхий, онцгой цочроомтгой," гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл**

Химийн хорт бодисоос хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"3.Химийн хорт бодисын ашиглалт, зарцуулалтын талаархи бодлого, зохицуулалтын асуудлаар мэргэжлийн дүгнэлт гаргах, зөвлөх эрх бүхий орон тооны бус үндэсний /цаашид "Зөвлөл" гэх/ болон салбар зөвлөл төв, орон нутагт ажиллах бөгөөд Зөвлөлийн дүрмийг Засгийн газар батална."

**4 дүгээр зүйл.**

Химийн хорт бодисоос хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 6 дахь заалтаас "болон химийн зэвсгийн" гэснийг хассугай.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА** **Р.ГОНЧИГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

**2000 оны 5 дугаар сарын 04-ний өдөр** **Дугаар 38** **Улаанбаатар хот**

### Монголбанкны худалдан авах алт болон Монголбанкнаас худалдах алт, мөнгөний хэмжээ тогтоох тухай

Эрдэнэсийн сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 3, 5 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Алт олборлодог аж ахуйн нэгжүүдээс 2000 онд Монголбанкны худалдан авах алтны доод хэмжээг 9000 килограмм байхаар тогтоосугай.

2.Дотоодын үйлдвэрлэлийн хэрэгцээнд зориулж 2000 онд Монголбанкнаас худалдах алтны хэмжээг 50.0 килограмм, мөнгөний хэмжээг 500.0 килограмм байхаар тус тус тогтоосугай.

3.Эрдэнэсийн гүйлгээний санд үйлдвэрүүдээс худалдан авсан алтыг тухай бүр олон улсын стандартад хүргэн зохих журмын дагуу цэвэршүүлж, үнийн таатай нөхцөлд борлуулж, улсын валютын нөөцийг нэмэгдүүлэх арга хэмжээ авч байхыг Монголбанк /Ж.Үнэнбат/-нд зөвшөөрсүгэй.

**ДАРГА** **Р.ГОНЧИГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2000 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр** **Дугаар 48** **Улаанбаатар хот**

**Н. Володя, Ц. Ганбат нарыг шүүгчийн албан тушаалаас огцруулах тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн тавин нэгдүгээр зүйлийн 4 дэх хэсэг, Шүүхийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, мөн хуулийн 52 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтыг тус тус баримтлан ЗАРЛИГ болгох нь:

Шүүн таслах ажиллагаанд дутагдал гаргасан Натаагийн Володяг Нийслэлийн Баянзүрх дүүргийн шүүхийн шүүгчийн, архидан согтуурч ёс суртахууны дутагдал гаргасан Цэвгээгийн Ганбатыг Ховд аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн шүүгч, ерөнхий шүүгчийн албан тушаалаас тус тус огцруулсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2000 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр** **Дугаар 49** **Улаанбаатар хот**

**Лувсанцэрэнгийн Галмандахад Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай**

Ерөнхий боловсролын сургуульд олон жил санаачлага, үр бүтээлтэй багшилж, хүүхдийн дууны ая, дан хөгжмийн зохиол олныг туурвиж, хүүхэд залуучуудад хөгжмийн боловсрол олгоход оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Нийслэлийн арван жилийн 52 дугаар сургуулийн дуу, хөгжмийн багш Лувсанцэрэнгийн Галмандахад Монгол Улсын гавьяат багш цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2000 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр** **Дугаар 50** **Улаанбаатар хот**

**Цэндхүүгийн Хандад Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай**

Ерөнхий боловсролын сургуульд олон жил санаачлага, үр бүтээлтэй багшилж физикийн сургалтын агуулага, арга зүйг боловсронгуй болгож, сурагчдад гүн бат мэдлэг олгох, өсвөр үеийг сурган хүмүүжүүлэх үйлст оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Нийслэлийн арван жилийн 28 дугаар дунд сургуулийн физикийн багш Цэндхүүгийн Хандад Монгол Улсын гавьяат багш цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2000 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр** **Дугаар 51** **Улаанбаатар хот**

**Цэндсүрэнгийн Энхманлайд Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээх тухай**

Дууны үг, ая олныг зохиож, хөгжимдөн дуулж, дан болон жүжиг, киноны хөгжмийн зохиол бичиж, рок поп урлагийн залуу үеийг сургаж бэлтгэх, эстрад урлагийг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Улсын филармонийн дэргэдэх "Харанга" хамтлагийн ахлагч Цэндсүрэнгийн Энхманлайд Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр | Дугаар 52 | Улаанбаатар хот

### Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай

Үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа, боловсрол, эрүүл мэнд, соёл урлаг, аялал жуулчлал, хоршоолол, төр, захиргаа, эрдэм шинжилгээний болон төрийн бус байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж, амжилт гаргасан дор дурьдсан хүмүүсийг одон, медалиар шагнасугай.

ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

1. Очирчүлтэмийн Ариунболд -Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын "Тэмүүлэл" цогцолбор сургуулийн биеийн тамирын багш

2. Жамбын Балган - Эх нялхсын эрдэм шинжилгээний улсын төвийн тасгийн эрхлэгч, их эмч

3. Гэнэнгийн Батбаяр - Бүх цэргийн дуу, бүжгийн чуулгын гоцлол дуучин

4. Жамьянгийн Батдорж - Увс аймгийн Нэгдсэн эмнэлгийн мэс заслын ерөнхий мэргэжилтэн, тасгийн эрхлэгч

5. Цэрэндоржийн Батдорж - Төрийн ёслолын албаны дэс түшмэл

6. Даваажавын Батсүх - Баянхонгор аймгийн Боловсрол, соёлын төвийн захирал

7. Банзрагчийн Батчулуун - П.Н. Шастины нэрэмжит клиникийн 3 дугаар нэгдсэн эмнэлгийн эмчилгээ эрхэлсэн орлогч дарга, мэдрэлийн мэс засалч, их эмч

8. Нанзадын Ганбаяр - Шүүхийн ерөнхий зөвлөлийн нарийн бичгийн дарга

9. Норовын Даваа - Сэлэнгэ аймгийн нийтийн аж ахуй, үйлчилгээний газрын дарга

10. Жаргалын Дагва - Нийслэлийн "Туушин" ХХК-ийн ерөнхий нягтлан бодогч

11. Жамбалын Далантай - Ахмад уран бүтээлчдийн "Алтан үе" чуулгын гоцлол дуучин

12. Лувсангийн Ишдорж - Дорноговь аймгийн Засаг дарга

13. Чойжгаваагийн Наранбаатар - Анагаах ухааны их сургуулийн физиологийн тэнхмийн багш

14. Дашбалбарын Нямбаяр - Төрийн ёслолын албаны шинжээч

15. Халтарын Цэрэнчимэд - Монголын зохиолчдын хорооны Үлгэрийн танхимын жүжигчин

16. Гүнсэнжавын Чулуунбаатар - Увс аймгийн Хөгжимт драмын театрын ерөнхий найруулагч

"АЛТАН ГАДАС" ОДОНГООР:

1. Далхсүрэнгийн Алтангэрэл - Хөвсгөл аймгийн засаг даргын тамгын газрын дарга бөгөөд төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн дарга

2. Тогтохын Алтанцэцэг - Монгол телевизийн боловсон хүчин хариуцсан ажилтан

3. Отгоны Алтанцэцэг - Сэлэнгэ аймгийн Ерөө сумын "Бугант" ХК-ийн мод үржүүлгийн инженер

4. Дашжамцын Арвин - Нийслэлийн аялал жуулчлал, барилга, үйлчилгээний "Их өргөө" ХК-ийн захирал

5. Цоодолын Баатар - Өвөрхангай аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга

6. Мишигийн Бадарч - Булган аймгийн Булган сумын "Буяны рашаан" хувийн эмнэлгийн шүдний их эмч

7. Шаравбалдангийн Бадарчин - Сүхбаатар аймгийн Онгон сумын Засаг дарга

8. Содномдаржаагийн Балдансамбуу - Архангай аймгийн үйлдвэр, үйлчилгээний хоршоодын холбооны дарга

9. Баянхутагийн Батбаяр -Нийслэлийн 127 дугаар цэцэрлэг-бага сургуулийн захирал

10. Мягмарын Батжаргал - Увс аймгийн Засаг даргын Тамгын газрын түшмэл

11. Санжаагийн Батмөнх - Ховд аймгийн Манхан сумын Зэрэг гол багийн Засаг дарга

12. Аюушжавын Бат-Очир - Төв аймгийн Эрдэнэсант сумын Засаг даргын Тамгын газрын ажилтан

13. Доржийн Бат-Очир - Улсын багшийн их сургуулийн уран зохиолын тэнхмийн багш

14. Галсангийн Батсүх - Нийслэлийн "Жуулчин" ХК-ийн Америкийн нэгдсэн улс дахь төлөөлөгч

15. Хатуугийн Батсүх - Увс аймгийн иргэдийн төлөөлөгчдын хурлын тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга

16. Лидагийн Болдбаатар - Техникийн их сургуулийн эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн проректор

17. Батсүхийн Бордух - Нийслэлийн 3 дугаар цахилгаан станцын засвар механикийн цехийн дарга

18. Жамсрангийн Бугалжаа - Ховд аймгийн нийгмийн даатгалын хэлтсийн ахлах мэргэжилтэн

19. Олдохын Буянтогтох - Сэлэнгэ аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга

20. Дэмбэрэлийн Вандан - Сэлэнгэ аймгийн Сант сумын Засаг дарга

21. Лувсаннямын Гавалмаа - Нийслэлийн 1 дүгээр дунд сургуулийн бага ангийн багш

22. Готовын Ганхуяг - Баянхонгор аймгийн Жаргалант сумын Засаг дарга

23. Нямаагийн Гэжээ - Увс аймгийн Засаг даргын Тамгын газрын ажилтан

24. Базарын Даваадорж - Нийслэлийн 3 дугаар цахилгаан станцын вагон хөмрөгчийн мастер

25. Жамбалжавын Даваажанцан - Хөвсгөл аймгийн нийгмийн эрүүл мэндийн төвийн мэдрэл сэтгэц наркологийн их эмч

26. Энэбишийн Дашцоо - Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Засаг дарга

27. Баатарын Дашцэрэн - Ховд аймгийн Жаргалант сум дахь геологи, шинжилгээний "Алтай нэгдэл" ХК-ийн инженер-геологич

28. Будын Жавзандулам - Нийслэлийн Д.Нацагдоржийн нэрэмжит музейн жижүүр

29. Найдангийн Жамъянцэрэн - Нийслэлийн Эрчим хүчний засварын үйлдвэрийн засварчин

30. Янсангийн Жигжид - Сэлэнгэ аймгийн Мандал сумын Засаг дарга

31. Баваасангийн Зундуй - Нийслэлийн 4 дүгээр дунд сургуулийн физикийн багш

32. Сундуйн Лхагвасүрэн - Төрийн хянан шалгах хорооны Тамгын Хэлтсийн дарга

33. Чойжингийн Нацагдорж - Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан

34. Дамбийн Норовдорж - Төрийн ёсполын албаны шинжээч

35. Шагдарсүрэнгийн Нэргүй - Нийслэлийн "Жуулчин" ХК-ийн дэд захирал

36. Найдангийн Нямаа - Нийслэлийн 42 дугаар дунд сургуулийн түүх, газарзүйн багш

37. Санжидын Нямдорж - Дундговь аймгийн ахмадын хорооны зохион байгуулагч, нягтлан бодогч

38. Шинэнгийн Нямсүрэн - Нийслэлийн үйлдвэрлэл, үйлчилгээний "Эрдэнэ тавуул" ХХК-ийн ерөнхий менежер

39. Жоосамбуугийн Одмаа - Бүх цэргийн дуу, бүжгийн чуулгын гоцлол дуучин

40. Жанцангийн Одонмажиг - Сүхбаатар аймгийн Онгон сумын дунд сургуулийн орос хэлний багш

41. Хайдавын Оросоо - Говь-Алтай аймгийн Анагаах ухааны коллежийн захирал

42. Лундэнгийн Отгон - Нийслэлийн 40 дүгээр дунд сургуулийн бага ангийн багш

43. Дамбын Оюунбадрах - Улсын багшийн их сургуулийн уран зохиолын тэнхмийн эрхлэгч

44. Данзангийн Тогоохүү - Өвөрхангай аймгийн Уянга сумын Засаг дарга

45. Чултэмийн Тэрбиш - Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын "Тэмүүлэл" цогцолбор сургуулийн бага ангийн багш

46. Сэнгийн Пэлжээ - Нийслэлийн "Хаш" зоогийн газрын ахлах тогооч

47. Гочоогийн Хайнжамц - Төрийн хянан шалгах хорооны хянан байцаагч

48. Дэмбэрэлийн Санжидгүнтэв - Дорноговь аймгийн Өргөн сумын "Шинэ-Өрнөх амьдрал"

хоршооны дарга

49. Болдын Сүхбаатар - Сүхбаатар аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга

50. Бултүүшийн Цэдэнбаа - Сэлэнгэ аймгийн Мандал сумын "Спирт бал бурам" ХК-ийн ажилчин

51. Хандсүрэнгийн Цэнд-Аюуш - Дундговь аймгийн худалдаа үйлдвэрлэлийн "Нарлаг мандал" ХХК-ийн захирал

52. Дамбийнямын Цэцгээ - Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын ахлах зааварлагч

53. Батхуягийн Шагжжав - Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн сургалтын албаны эрхлэгч

54. Чойжилын Шоовдор -Нийслэлийн Эрчим хүчний засварын үйлдвэрийн ерөнхий механикч

55. Жансангийн Шуумаржав - Улсын багшийн их сургуулийн дүрслэх урлаг, дизайны тэнхмийн багш

56. Цэрэнгийн Ядамжав - Улсын багшийн их сургуулийн дүрслэх урлаг, дизайны тэнхмийн багш

ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ ОДОНГООР:

1. Бат-Очирын Дэмбээ -Хөвсгөл аймгийн Арбулаг сумын өндөр настан, ахмад дайчин

ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕАЛИАР:

1. Сэрээнэнгийн Жамц - Нийслэлийн 3 дугаар цахилгаан станцын химийн цехийн дарга

2. Хадхүүгийн Жаргалсайхан - Техникийн их сургуулийн харьяа Уул уурхайн хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга

3. Түмэнгийн Мөнхбаяр- Сэлэнгэ аймгийн Ерөө сумын "Удмын сан" ҮҮГ-ын малын их эмч

4. Доржийн Сүхбаатар - Нийслэлийн Багануур дүүргийн Засаг даргын Тамгын газрын дэс түшмэл

5. Чимэдноровын Төмөр - Нийслэлийн Эрчим хүчний засварын үйлдвэрийн дарга

6. Бавуугийн Уртнасан - Дархан-Уул аймгийн Дархан сумын "Дархан" зочид буудлын үсчин

7. Тогмидын Цоодол - Сэлэнгэ аймгийн Хөтөл хотын "Цемент шохой" ҮҮГ-ын лаораторийн эрхлэгч

8. Шаравын Цэгмид - Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын "Тэмүүлэл" цогцолбор сургуулийн багш

9. Лувсан-Ёндонгийн Эрдэнтуяа - Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн орос хэл, уран зохиолын тэнхмийн багш

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2000 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр** **Дугаар 53** **Улаанбаатар хот**

**Очирбатын Нямдоржийг "Шудрага журам" медалиар шагнах тухай**

Эр зориг, авхаалж самбаа гарган үерийн уснаас хүүхдийн амь аварч иргэний үүргээ нэр төртэй биелүүлсэн Хөвсгөл аймгийн Мөрөн сумын арван жилийн 1 дүгээр сургуулийн 4 дүгээр ангийн сурагч Очирбатын Нямдоржийг "Шударга журам" медалиар шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2000 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр** **Дугаар 54** **Улаанбаатар хот**

**Жадамбаагийн Мөнхзулыг "Шудрага журам" медалиар шагнах тухай**

Эр зориг, авхаалж самбаа гарган галын аюулаас хүүхдийн амь аварч иргэний үүргээ нэр төртэй биелүүлсэн нийслэлийн "Улаанбаатар хот орчмын зам засвар, арчлалт, хангамжийн компани" /ҮҮГ"-ийн замчин Жадамбаагийн Мөнхзулыг "Шударга журам" медалиар шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2000 оны 03 дугаар сарын 15-ны өдөр** | **Дугаар 38** | **Улаанбаатар хот**

**Тогтоолын заалтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай**

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1."Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан буюу Хүндэт тэмдгийн тухай" Засгийн газрын 1997 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтад дор дурдсан агуулгатай 41 дэх хэсэг нэмсүгэй:

"41. Аялал жуулчлалын тэргүүний ажилтан тэмдэг

2."Аялал жуулчлалын тэргүүний ажилтан" тэмдгийг олгох журмыг боловсруулан баталж мөрдүүлэхийг Дэд бүтцийн хөгжлийн сайд Г.Батхүүд даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд Р.АМАРЖАРГАЛ

Дэд бүтцийн хөгжлийн сайд Г.БАТХҮҮ

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2000 оны 03 дугаар сарын 15-ны өдөр** | **Дугаар 39** | **Улаанбаатар хот**

**2000 оны төвлөрсөн төсвийг биелүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай**

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Улсын төвлөрсөн төсөвт 2000 онд татвар, хураамж болон бусад орлого төвлөрүүлэх аж ахуйн нэгж, байгууллагын жагсаалтыг 1 дүгээр хавсралтаар, улсын төвлөрсөн төсвөөс нийслэлийн төсөвтэй харьцуулахаар шилжүүлэх аж ахуйн нэгж, байгууллагын жагсаалтыг 2 дугаар хавсралтаар, улсын төвлөрсөн төсвийн хөрөнгө оруулалтаар 2000 онд санхүүжүүлэх барилга, байгууламж, төсөл арга хэмжээний жагсаалтыг 3 дугаар хавсралтаар, улсын төвлөрсөн төсвийн хөрөнгө оруулалтын зориулалтаар замын сангаас болон төвлөрсөн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх зам, гүүрийн барилга, байгууламжийн жагсаалтыг 4 дүгээр хавсралтаар тус тус батлсугай.

2.Сангийн сайд Я.Очирсүхэд даалгах нь:

а/хөрөнгийн эх үүсвэргүйгээс 1999 онд санхүүжигдээгүй 5 дугаар хавсралтад дурдсан барилга байгууламж, төсөл арга хэмжээг 2000 оны Ш улиралд багтаан санхүүжүүлсүгэй;

б/улсын төвлөрсөн төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр барих барилга байгууламж, хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнүүдээс боловсрол, эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалт, их засварын ажлыг тэргүүн ээлжинд санхүүжүүлэх арга хэмжээ авч ажилласугай.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Улсын төвлөрсөн төсвийн гүйцэтгэлийг хангаж биелүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 1997 оны 1 дүгээр сарын 2-ны өдрийн 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд Р.АМАРЖАРГАЛ

Сангийн сайд Я.ОЧИРСҮХ

*Засгийн газрын 2000 оны 39 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт*

## УЛСЫН ТӨВЛӨРСӨН ТӨСӨВТ ТАТВАР, ХУРААМЖ БОЛОН БУСАД ОРЛОГО ТӨВЛӨРҮҮЛЭХ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГУУДЫН ЖАГСААЛТ

1. Эрчим хүчний удирдах газар
2. "Эрдэнэт" үйлдвэр
3. "Монголросцветмет" нэгдэл
4. "Монгол-Чех металл" нэгдэл
5. "Шижир-Алт"хязгаарлагдмал хариуцлагатай компани
6. "Говь" хувьцаат компани
7. "Улаанбаатар хивс" хувьцаат компани
8. "Нэхий" хувьцаат компани
9. "Архи, пиво, ундаа" хувьцаат компани
10. "Спирт бал бурам" хувьцаат компани
11. "Дархан гурил тэжээл" хувьцаат компани
12. "Алтан тариа" хувьцаат компани
13. "Нефть импорт концерн" хувьцаат компани
14. "Петровис"хязгаарлагдмал хариуцлагатай компани
15. "Монголын цахилгаан холбоо" хувьцаат компани
16. Шуудан цахилгаан холбооны газар
17. "Миком" хязгаарлагдмал хариуцлагатай компани
18. "Скайтель"хязгаарлагдмал хариуцлагатай компани
19. Монгол шуудан компани
20. Иргэний нисэхийн ерөнхий газар
21. "Монголын иргэний агаарын тээвэр" компани
22. Төмөр замын хэрэг эрхлэх газар
23. Худалдаа хөгжлийн банк
24. Шинэчлэл банк
25. Монгол шуудан банк
26. Голомт банк
27. Хөдөө аж ахуйн банк
28. Тээвэр хөгжлийн банк
29. Эрэл банк
30. Кредит банк
31. Зоос банк
32. Анод банк
33. Улсын гаалийн ерөнхий газар
34. Үндэсний татварын ерөнхий газар
35. Төрийн өмчийн хороо
36. Улсын нийгмийн даатгалын ерөнхий газар
37. Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төв
38. Ашигт малтмалын хэрэг эрхлэх газар
39. Байгаль орчныг хамгаалах алба
40. Газрын тосны хэрэг эрхлэх газар
41. Сорьцын хяналтын улсын алба
42. Банкны өр барагдуулах алба
43. Хадгаламж банк

*Засгийн газрын 2000 оны 39 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт*

## УЛСЫН ТӨВЛӨРСӨН ТӨСВӨӨС НИЙСЛЭЛИЙН ТӨСӨВТЭЙ ХАРЬЦУУЛАХААР ШИЛЖҮҮЛЭХ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГУУДЫН ЖАГСААЛТ

1. "Монгол нэхмэл" хувьцаат компани
2. "Сор" хувьцаат компани
3. "Монгол савхи" хувьцаат компани
4. "Нэхээсгүй эдлэл" хувьцаат компани
5. "Материал импекс" хувьцаат компани
6. "Бөөний худалдаа" хувьцаат компани
7. "Разноимпекс нэгтгэл" хувьцаат компани
8. "Хүнстрейд" улсын үйлдвэрийн газар
9. "Монгол импекс" улсын үйлдвэрийн газар
10. "Монгол экспорт" хязгаарлагдмал хариуцлагатай компани
11. "Монгол худалдаа" хязгаарлагдмал хариуцлагатай компани

Засгийн газрын 2000 оны
39 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт

## УЛСЫН ТӨВЛӨРСӨН ТӨСВӨӨС НИЙСЛЭЛИЙН ТӨСӨВТЭЙ ХАРЬЦУУЛАХААР ШИЛЖҮҮЛЭХ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГУУДЫН ЖАГСААЛТ

(сая төг)

| д/д | Төсөл, арга хэмжээний нэр, байршил, хүч чадал | Эхлэх дуусах хугацаа | Нийт төсөвт өртөг | Үүнээс 2000 онд санхүүжих | Ерөнхий захиалагч |
|---|---|---|---|---|---|
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| | **I. ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАР** | | **12895.9** | **8654.0** | |
| | **1.ДУЛААНЫ СТАНЦ** | | **6093.0** | **3943.0** | |
| 1 | Чойбалсан сумын дулааны цахилгаан станцын шинэчлэлтийн Монголын талын хөрөнгө | 1999-2000 | 1000.0 | 650.0 | ДБХЯ |
| 2 | Даланзадгад сумын дулааны цахилгаан станцын инженерийн гадна шугам сүлжээ | 1999-2000 | 2400.0 | 2300.0 | ДБХЯ |
| 3 | Дулааны гадна шугам, ф-1000 мм, 6.1 км, (ТЭЦ 3-ТЭЦ 4-ийн хооронд) Улаанбаатар | 1999-2001 | 2000.0 | 300.0 | ДБХЯ |
| 4 | Дулааны төв шугамын шинэчлэлт, Сайншанд | 2000-2000 | 208.0 | 208.0 | ДБХЯ |
| 5 | Биокомбинатын гадна дулааны шугамын шинэчлэлт УБ | 2000-2000 | 410.0 | 410.0 | ДБХЯ |
| 6 | Дулаан, цэвэр усны шугамын шинэчлэлт, Говьсүмбэр | 2000-2000 | 75.0 | 75.0 | ДБХЯ |
| | **2.ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ШУГАМ, ДЭД ӨРТӨӨ** | | **6802.9** | **4711.0** | |
| 1 | Луус-Эрдэнэдалай сум, 35 кВ, 1х1мва, 86км, Дундговь | 1999-2000 | 1039.0 | 639.0 | ДБХЯ |
| 2 | Мянгад-Эрдэнэбүрэн сум, 35 кВ, 1х0,4мВа, 58,2км, Ховд | 1999-2000 | 740.9 | 541.0 | ДБХЯ |
| 3 | Баянгол-Сайхан-Овоо сум, 35 кВ, 1х0,4мва, 55км, Дундговь | 1999-2000 | 688.0 | 488.0 | ДБХЯ |
| 4 | Баянгол-Сант сум, 10 кВ, 1х0,4мВа, 50км, Өвөрхангай | 1999-2000 | 250.0 | 180.0 | ДБХЯ |
| 5 | Бүрэн-Дэлгэрхаан сум, 35 кВ, 1х1мва, 50км, Төв | 1999-2000 | 776.0 | 356.0 | ДБХЯ |
| 6 | Баруун-Урт-Халзан сум, 35 кВ, 1х0,63 мва, 62.2 км, Сүхбаатар | 2000-2000 | 905.0 | 905.0 | ДБХЯ |
| 7 | Бэрх-Батноров сум, 35 кВ, 1х0,4 мва, 35 км, Хэнтий. | 2000-2000 | 572.0 | 572.0 | ДБХЯ |
| 8 | Өндөр-Улаан-Тариат сум, 35 кВ, 1х0,4 мВа, 52 км, Архангай. | 2000-2000 | 800.0 | 800.0 | ДБХЯ |
| 9 | Дэлгэрхаан-Баян-Өндөр сум, 10 кВ, 1х0,4 мВа, 40 км, Өвөрхангай | 2000-2001 | 232.0 | 30.0 | ДБХЯ |
| 10 | Сэргээгдэх эрчим хүч, Баянхонгор | 2000-2001 | 800.0 | 200.0 | ДБХЯ |
| | **II. НҮҮРСНИЙ САЛБАР** | | **110.0** | **50.0** | |
| 1 | Олонбулагийн нүүрсний уурхай, Ховд, Үенч сум | 2000-2001 | 110.0 | 50.0 | ДБХЯ |
| | **III. ТЭЭВЭР** | | **828.9** | **400.0** | |
| 1 | Нисэх буудлын барилга, Баян-Өлгий | 2000-2001 | 828.9 | 400.0 | ДБХЯ |
| | **IV. ХОТ БАЙГУУЛАЛТ** | | **2794.1** | **1631.0** | |
| | **1.АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭ** | | **2434.1** | **1271.0** | |
| 1 | Цэвэр усны шугам, 2700м3/хоног, Арвайхээр | 1999-2000 | 175.0 | 100.0 | ДБХЯ |
| 2 | Цэвэрлэх байгууламжийн дуусгал, 1200 м3/хоног, Өндөрхаан. | 1993-2000 | 209.5 | 163.0 | ДБХЯ |
| 3 | Цэвэр усны системийн дуусгал, туршилт, тохируулга. Цэцэрлэг | 2000-2000 | 70.0 | 70.0 | ДБХЯ |
| 4 | Хлоржуулах системийн шинчлэлт Архангай, Дорнод, Өмнөговь | 2000-2000 | 50.0 | 50.0 | ДБХЯ |

| A | 1 | 2 | 3 | 4 | 5 |
|---|---|---|---|---|---|
| 5 | Баруун 5 аймгийн НААҮ-г сэргээн хөгжүүлэх төслийн Монголын талын хөрөнгө | 1998-2000 | 714.0 | 172.0 | ДБХЯ |
| 6 | Сумдын сургуулийн халуун ус | 2000-2000 | 150.0 | 150.0 | ДБХЯ |
| 7 | Цэвэр усны өндрийн сангийн дуусгал, 6000 м3, Дархан-уул. | 1990-2000 | 459.6 | 260.0 | ДБХЯ |
| 8 | Хөдөөгийн сум суурин газрын ус хангамж, ариун цэврийг сайжруулах төсөл | 2000-2000 | 6.0 | 6.0 | ДБХЯ |
| 9 | Бохир усны шугам 3,1 км Улаанбаатар | 2000-2001 | 600.0 | 300.0 | ДБХЯ |
| | **2.ОРОН СУУЦ** | | **360.0** | **360.0** | |
| 1 | УИХ-ын гишүүд болон Тамгын газрын ажилтнуудад байр худалдан авах | 2000-2000 | 160.0 | 160.0 | УИХТГ |
| 2 | Улс төрийн талаар хилс хэрэгт хэлмэгдсэн иргэд болон тэдгээрийн ар гэрийнхэнд байр худалдан авах, /120 айл/ | 2000-2000 | 200.0 | 200.0 | ДБХЯ |
| | **V. ХӨДӨӨ АЖ АХУЙ** | | **190.0** | **90.0** | |
| 1 | Усалгаатай тариалан эрхлэх Ховдын Булган, Үенч сум (500-5000 га), гурилын үйлдвэр, Булган сум | 2000-2001 | 190.0 | 90.0 | ХААҮЯ |
| | **VI. ЭРҮҮЛ МЭНД** | | **2754.0** | **807.0** | |
| 1 | Эрүүл мэндийн хөгжлийн хөтөлбөрийн Монголын талын хөрөнгө. | 1998-2002 | 2644.0 | 697.0 | ЭМНХЯ |
| 2 | Нэгдсэн эмнэлгийн В,Г блокийг аймаг дундын эмчилгээ оношилгооны төв болгох, Өвөрхангай | 2000-2000 | 100.0 | 100.0 | ЭМНХЯ |
| 3 | Эмнэлгийн дуусгал, Хөвсгөл, Жаргалант сум | 2000-2000 | 10.0 | 10.0 | ЭМНХЯ |
| | **VII. ГЭГЭЭРЭЛ** | | **3042.9** | **2049.8** | |
| | **1.БОЛОВСРОЛ** | | **2656.1** | **1856.0** | |
| 1 | МСҮТ-ийн өргөтгөл, Увс | 1999-2000 | 240.0 | 200.0 | ЗДТГ |
| 2 | Сургуулийн барилга, 240 суудал, Архангай, Цахир сум | 1999-2000 | 240.0 | 120.0 | ЗДТГ |
| 3 | 8 жилийн сургуулийн дуусгал, Архангай, Жаргалант сум | 1995-2001 | 205.0 | 75.0 | ЗДТГ |
| 4 | Сургуулийн барилга 240 суудал, Өмнөговь, Цогт-Овоо сум | 1999-2000 | 200.0 | 100.0 | ЗДТГ |
| 5 | Сургуулийн барилга, 320 суудал. 13-р хороолол, Улаанбаатар | 1999-2000 | 350.0 | 300.0 | ЗДТГ |
| 6 | Сургуулийн барилга, 320 суудал, Хэнтий Бор-Өндөр сум | 2000-2001 | 400.0 | 200.0 | ГЯ |
| 7 | Сургуулийн барилгын дуусгал, 928 суудал, Хэнтий, Өндөрхаан сум | 1998-2000 | 210.1 | 200.0 | ГЯ |
| 8 | Сургуулийн барилгын дуусгал,320 суудал, Баянхонгор, Баянцагаан сум | 2000-2000 | 51.0 | 51.0 | ЗДТГ |
| 9 | 8 жилийн 5-р сургуулийн "А" блокийн дуусгал, Баян-өлгий, Өлгий сум | 2000-2000 | 200.0 | 200.0 | ГЯ |
| 10 | Сургуулийн барилга, 240 суудал, Сэлэнгэ, Сүхбаатар сум | 2000-2001 | 300.0 | 150.0 | ГЯ |
| 11 | Сургуулийн барилга, 160 суудал, Дорноговь, Эрдэнэ сум | 2000-2000 | 220.0 | 220.0 | ГЯ |
| 12 | 2 дугаар 10 жилийн сургууль Хөвсгөл, Мөрөн сум | 2000-2000 | 40.0 | 40.0 | ЗДТГ |
| | **2.СОЁЛ УРЛАГ, СПОРТ** | | **386.8** | **193.8** | |
| 1 | Аймгийн соёл, спортын төвийн барилгын дуусгал, Говь-Алтай. | 1989-2000 | 238.0 | 100.0 | ЗДТГ |
| 2 | Соёлын төвийн барилгын дуусгал Ховд, Алтай сум | 1998-2000 | 117.0 | 62.0 | ГЯ |
| 3 | Ж.Лхагвасүрэнгийн хөшөөний барилга УБ | 2000-2000 | 31.8 | 31.8 | Нийслэлийн ЗДТГ |

### ХӨРӨНГИЙН ЭХ ҮҮСВЭРГҮЙГЭЭС 1999 ОНД САНХҮҮЖИГДЭЭГҮЙ БАРИЛГА БАЙГУУЛАМЖ, ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

/сая төг/

| A | 1 | 2 | 3 | 4 | 5 |
|---|---|---|---|---|---|
| | **VIII. БАТЛАН ХАМГААЛАХ** | | **721.0** | **483.0** | |
| 1 | Бригадын цэргийн байр, Өвөрхангай | 1999-2000 | 150.0 | 100.0 | БХЯ |
| 2 | Тусгай салбарын байр, Ховд, Үенч сум. | 2000-2000 | 48.0 | 48.0 | БХЯ |
| 3 | Тусгай салбарын байр, Говь-Алтай, Алтай сум. | 2000-2000 | 72.0 | 72.0 | БХЯ |
| 4 | Цэргийн байр, 200 хүн, Орхон | 2000-2001 | 195.0 | 100.0 | БХЯ |
| 5 | 48 айлын орон сууц, Өвөрхангай. | 2000-2001 | 256.0 | 163.0 | БХЯ |
| | **IX. ГАДААД ХАРИЛЦАА** | | **800.0** | **800.0** | |
| 1 | Берлин дэх ЭСЯ-нд байр худалдан авах. | 2000-2000 | 800.0 | 800.0 | ГХЯ |
| | **X. НИЙГМИЙН ХЭВ ЖУРАМ, АЮУЛГҮЙ БАЙДАЛ** | | **885.0** | **500.0** | |
| 1 | "Ганц худаг"-ийн урьдчилан хорих төв | 1999-2000 | 400.0 | 255.0 | ЦЕГ |
| 2 | Цагдан хорих байрны өргөтгөл, Төв. | 2000-2000 | 65.0 | 65.0 | ЦЕГ |
| 3 | Цагдаагийн хэлтэс, цагдан хорих байр, Мандалговь | 2000-2000 | 100.0 | 100.0 | ЦЕГ |
| 4 | Галын депо, 5 машины гараж, Булган. | 1999-2000 | 320.0 | 80.0 | ГТГ |
| | **XI. ХИЛ ХАМГААЛАЛ** | | **1429.0** | **844.0** | |
| 1 | Хойд хилийн дагуу тор татах | 2000-2000 | 197.0 | 197.0 | ХЦУГ |
| 2 | Буга согоогийн застав, Завхан | 2000-2000 | 115.0 | 115.0 | ХЦУГ |
| 3 | Нисэхийн застав, цэргийн байр, уулзалтын байр, гал зуух, Завхан | 2000-2000 | 88.0 | 88.0 | ХЦУГ |
| 4 | Тамсаг булагт хилийн отрид байгуулах, Дорнод | 1999-2001 | 735.0 | 150.0 | ХЦУГ |
| 5 | Тэрэгтийн застав, Сүхбаатар | 2000-2000 | 119.0 | 119.0 | ХЦУГ |
| 6 | Ар булгийн застав, Дорноговь | 2000-2000 | 103.0 | 103.0 | ХЦУГ |
| 7 | Хилийн хорооны бохирын шугамын холболт, Сэлэнгэ | 2000-2000 | 24.0 | 24.0 | ХЦУГ |
| 8 | Хилийн заставуудын өрөмдмөл худаг | 2000-2000 | 48.0 | 48.0 | ХЦУГ |
| | **XII. ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛ** | | **337.0** | **337.0** | |
| 1 | Хоригдлын ажлын байр бий болгох | 2000-2000 | 267.0 | 267.0 | ХЗЯ |
| 2 | Цэргийн байр / Мааньт, Хөвсгөл/ | 2000-2000 | 70.0 | 70.0 | ХЗЯ |
| | **БАРИЛГА УГСРАЛТЫН НИЙТ ДҮН** | | **26787.8** | **16645.8** | |
| XIII | Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний бэлтгэл ажлын зардал. | | | 200.0 | СЯ |
| XIV | Тоног төхөөрөмж | | 2370.4 | 2243.4 | СЯ |
| | **ТӨВЛӨРСӨН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ДҮН** | | **29158.2** | **19089.2** | |
| XY | Их засвар | 1999-2000 | 6115.5 | 2400.0 | СЯ |
| XVI | Замын сан | 1996-2003 | 35077.0 | 10164.4 | ДБХЯ |
| | үүнээс: Улсын замын сан | | | 4383.5 | |
| | Төвлөрсөн төсвийн санхүүжилт | | | 5780.9 | |
| XVII | Гаалийн сан | 1998-2000 | 4523.0 | 3000.0 | УГЕГ |
| | **НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ДҮН** | | **74873.7** | **34653.6** | |

засгийн газрын [illegible]
тогтоолын 4 дүгээр хавсралт

## УЛСЫН ТӨВЛӨРСӨН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗОРИУЛАЛТААР ЗАМЫН САНГААС БОЛОН ТӨВЛӨРСӨН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР САНХҮҮЖҮҮЛЭХ ЗАМ, ГҮҮРИЙН БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТ

(сая төг)

| № | Төсөл, арга хэмжээний нэр байршил | Хүчин чадал | Барих хугацаа | Төсөвт өртөг | 2000 оны төсөл | Үүнээс: Замын сан | Үүнээс: Орон нутгийн замын сан | Үүнээс: Улсын төсөв | Ашиглалтад оруулах: Хүчин чадал | Ашиглалтад оруулах: Улирал |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
| А | 1 | | | | | | | | | |
| | **Нэг. Хатуу хучилттай зам** | 3.2 км | 1996-2000 | 228.9 | 132.5 | 72.0 | 60.5 | 900.0 | 3.2 км | III |
| 1 | Замын-Үүд | 37.5 | 1999-2001 | 2,625.0 | 1,000.0 | 43.6 | 56.4 | | | |
| 2 | Багануурын чиглэлийн зам | | | | | | | | 171м | IY |
| | **Хоёр. Төмөр бетон гүүр** | 171м | 1996-2000 | 571.3 | 289.7 | 225.1 | 64.6 | | | |
| 1 | Архангайн Өлзийт, Орхон гол | 162,9 м | 1999-2001 | 280.0 | 100.0 | 24.3 | 75.7 | | 170м | III |
| 2 | Хөвсгөлийн Галт, Идэрийн гол. | 170 м | 1993-2000 | 510.0 | 158.0 | 63.0 | 95.0 | | 144.9м | IY |
| 3 | Сэлэнгэ Зүүнхараа, Хараа гол | 144,9 м | 1995-2000 | 440.1 | 355.0 | 279.8 | 75.2 | | | |
| 4 | Завханы Баянтэс, Тэсийн гол | 289,3 м | 1994-2001 | 1,137.2 | 400.0 | 340.3 | 59.7 | | 72 м | IY |
| 5 | Булганы Тэшиг, Эгийн гол | 72 м | 1999-2000 | 277.6 | 267.6 | 206.7 | 60.9 | | | |
| 6 | Увс Гашууны гол | | | | | | | | 87.8м | III |
| | **Гурав. Модон гүүр** | 87,8 м | 1999-2000 | 70.0 | 20.0 | | 20.0 | | | |
| 1 | Дорнод Эрээнцав, Улз гол | | 1999-2000 | 1,050.0 | 1,050.0 | 1,050.0 | | | | |
| | **Дөрөв. "Авто замын хууль" -ийн дагуу санхүүжүүлэх бусад арга хэмжээ, улсын зам засварт** | | 2000 | 2,590.6 | 1,349.5 | | 1,349.5 | | | |
| | **Тав. Орон нутгийн замын санд төвлөрүүлэх хөрөнгө** | | 2000 | 1,100.0 | 1,100.0 | | 1,100.0 | | | |
| | Үүнээс : Улаанбаатар хотод | | | | | | | | | |
| | **Зургаа. Гадаадын зээлийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төслийн дотоод эх үүсвэр** | | | | | | | | | |
| 1 | Кувейтын сангийн зээлээр хэрэгжиж байгаа Дархан-Эрдэнэтийн хатуу хучилттай замын Монголын талын | 184 км | 1996-2000 | 6,213.2 | 3,775.7 | 1,508.9 | 230.0 | 2,036.8 | 184 км | IY |
| 2 | АХБанкны зээлээр хэрэгжиж байгаа Улаанбаатар-Дархан-Алтанбулагийн замын өргөтгөл, шинэчлэлтийн ажлын Монголын талын хөрөнгө | 312 км | 1997-2000 | 6,102.0 | 3,275.0 | 569.8 | 231.1 | 2,474.1 | 312 км | IY |
| 3 | Дэлхийн банкны зээлийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа Хархорин- Цэцэрлэг-Тосонцэнгэлийн хэсэгчилсэн хайрган замын ажлын Монголын талын хөрөнгө | 80 км | 1997-2000 | 1,104.7 | 370.0 | | | 370.0 | 80 км | III |
| 4 | АХБанкны зээлээр хэрэгжих Налайх-Мааньт-Чойрын чиглэлийн замын ажлын Монголын талын хөрөнгө | км | 2000-2003 | 9,000.0 | 106.0 | | 106.0 | | | |
| 5 | Дэлхийн банкны зээлийн хөрөнгөөр хэрэгжих Эрдэнэсант-Арвайхээр-Ховд, Улаангом чиглэлийн замын ажлын Монголын талын хөрөнгө | км | 2000-2003 | 4,070.0 | 106.0 | | 106.0 | | | |
| | Дүн | | | | 12,755.0 | 4,383.5 | 2,590.6 | 5,780.9 | р | |

Засгийн газрын 2000 оны 39 дүгээр тогтоолын 5дугээр хавсралт

## ХӨРӨНГИЙН ЭХ ҮҮСВЭРГҮЙГЭЭС 1999 ОНД САНХҮҮЖИГДЭЭГҮЙ БАРИЛГА БАЙГУУЛАМЖ, ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

/сая төг/

| № | Төсөл, арга хэмжээний нэр | Хэрэгжүүлэх хугацаа | Үлдэгдэл санхүүжилт |
|---|---|---|---|
| А | 1 | 2 | 3 |
| I | **110, 35,10, 06 кВ-ын шугам, дэд өртөө** | | **2124.6** |
| 1 | Чойбалсан-Баруун-урт, 1х10;1х6.3мВа, 185.75 км | 1998-1999 | 183.3 |
| 2 | Иххэт-Алтанширээ, 35 кВ, 1х0.4 мВа, 102 км, Дорнговь | 1998-1999 | 76.0 |
| 3 | СагсайЦэнгэл, 10 кВ, 1х0.4 мВа, 37 км, БаянӨлгий | 1999 | 110.2 |
| 4 | Луус-Эрдэнэ далай, 35 кВ, 1х1 мВа, 85.6 км, Дундговь | 1999-2000 | 400.0 |
| 5 | Бүрэн-Дэлгэрхаан, 35 кВ,1х1 мВа, 50 км, Төв | 1999 | 320.0 |
| 6 | Мянгад-Эрдэнэбүрэн, 35 кВ, 1х04 мВа, 58,2 км, Ховд | 1999-2000 | 200.0 |
| 7 | БаянголСайхан-овоо, 35 кВ, 1х0.4 мВа, 55 км, Дундговь. | 1999-2000 | 180.0 |
| 8 | Луус-Хулд, 35 кВ, 1х1 мВа. 35 км, Дундговь. | 1999 | 526.0 |
| 9 | БаянголСант 10кВ, 1х0.4 мВа, 50 км, Өвөрхангай. | 1999-2000 | 70.0 |
| 10 | БаянхонгорШаргалжуут, 10 кВ, 1х0.4 мВа, 32.3 км, Баянхонгор. | 1999 | 50.0 |
| 11 | ХанхМонд, 10 кВ, 1х0.4 мва, 22 км, Хөвсгөл | 1999 | 9.1 |
| II | **Дулааны станц, төвлөрсөн зуух** | | **72.8** |
| 1 | Дорнодын станцын шинэчлэлийн Монголын талын хөрөнгө | 1998-2000 | 61.1 |
| 2 | Төвлөрсөн зуухны дуусгал, 2хКВТС20, Зуунмод | 1995-1999 | 11.7 |
| III | **Хот, нийтийн аж ахуй** | | **301.8** |
| 1 | Цэвэрлэх байгууламж, 2100 м3/ хон., Мандалговь | 1998-1999 | 136.2 |
| 2 | Цэвэр усны эх үүсвэрийн барилга, шугам, 2400 м3/хон., Баянхонгор | 1997-1999 | 60.0 |
| 3 | Марксын гудамжнаас Энх тайваны өргөн чөлөө хүртэлх цэвэр усны 0.7 км шугамыг 400 мм болгон өргөтгөх, Улаанбаатар. | 1998-1999 | 29.0 |
| 4 | Цэвэрлэх байгууламжийн дуусгал, Хөтөл | 1999 | 54.0 |
| 5 | Аймгуудын хлоржуулах систем | 1998-1999 | 22.6 |
| IY | **Боловсрол** | | **426.3** |
| 1 | Сургууль. 1176 суудал, Эрдэнэт | 1998-1999 | 184.8 |
| 2 | Сургуулийн дуусгал, 640 суудал, Уулбаян сум, Сүхбаатар | 1999 | 70.0 |
| 3 | Сургуулийн барилга, 240 суудал, Цахир сум, Архангай. | 1999-2000 | 20.0 |
| 4 | Сургуулийн барилга, 240 суудал, ЦогтОвоо сум, Өмнөговь. | 1999-2000 | 70.0 |
| 5 | Сургуулийн барилга 350 суудал, 13р хороолол, Улаанбаатар | 1999-2000 | 50.0 |
| 6 | "Боловсролын салбарын хөгжлийн хөтөлбөр"ийн Монголын талын зардал | 1999-2001 | 31.5 |
| Y | **Эрүүл мэнд** | | **125.3** |
| 1 | "Эрүүл мэндийн салбарын хөгжил" төслийн Монголын талын хөрөнгө | 1998-2002 | 125.3 |
| YI | **Түүх, дурсгал, спорт** | | **97.0** |
| 1 | Спорт цогцолборын дуусгал, Алтай хот | 1999 | 97.0 |
| YII | **Нийгмийн хэв журам, аюулгүй байдал** | | **138.0** |
| 1 | Галын депо, 5 машины гараж, Булган | 1999 | 70.0 |
| 2 | "Ганц худаг"ийн урьдчилан хорих байр | 1999-2000 | 68.0 |
| YIII | **Батлан хамгаалах** | | **50.0** |
| 1 | Бригадын цэргийн байр, Өвөрхангай | 1999 | 50.0 |
| IX | **Хилийн цэрэг** | | **50.0** |
| 1 | Тамсаг булагт хилийн отряд байгуулах, Дорнод | 1999-2000 | 50.0 |
| X | **Тоног төхөөрөмж** | | 842.8 |
| | **Төвлөрсөн төсвийн хөрөнгө оруулалтын дүн** | | **4228.6** |
| XI | **Их засвар** | 1999 | 127.0 |
| XII | **Замын сан** | 1994-2001 | 1659.3 |
| | **НИЙТ ДҮН** | | **6014.9** |

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2000 оны 3 дугаар сарын 15-ны өдөр** | **Дугаар 40** | **Улаанбаатар хот**

**Тогтоолыг өөрчлөн найруулах тухай**

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Галын аюулгүй байдлын тухай хуулийн дагуу Иргэний хамгаалалтын газар дахь ой, хээрийн түймэртэй тэмцэх чиг үүргийг хэрэгжүүлдэг алба, нэгжийг Гал түймэртэй тэмцэх газарт шилжүүлсэнтэй холбогдуулан "Зарим отряд, салбарыг өргөтгөх, байгуулах, санхүүжүүлэх тухай" Засгийн газрын 1999 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 169 дүгээр тогтоолын 1, 2 дугаар зүйлийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"1.Архангай, Дорнод аймгийн байгалийн гамшигтай тэмцэх салбар, нийслэлийн байгалийн гамшгаас аврах ангийг аврах отряд болгон өргөтгөх, Ховд аймагт аврах отряд, Төв аймагт аврах салбар байгуулах, эдгээр отряд, салбар болон Булган, Сэлэнгэ, Хөвсгөл, Хэнтий аймгийн аврах салбарыг техник хэрэгсэл, боловсон хүчин, мэргэжлийн аврагчдаар хангах арга хэмжээ авахыг Батлан хамгаалахын сайд, Улсын байнгын онцгой комиссын дарга Ш.Түвдэндорж, холбогдох аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

2.Аврах отряд, салбарын зардлыг тухайн аймаг, нийслэлийн төсвөөс, эдгээр аврах отряд, салбаруудыг өөр аймагт шилжүүлэн үүрэг гүйцэтгүүлсний зардлыг ажиллуулсан аймгийн төсвөөс тус тус санхүүжүүлж байхаар тогтоосугай."

Монгол Улсын Ерөнхий сайд Р.АМАРЖАРГАЛ

Батлан хамгаалахын сайд Ш.ТҮВДЭНДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2000 оны 3 дугаар сарын 15-ны өдөр** | **Дугаар 41** | **Улаанбаатар хот**

**Баруун аймгуудын талаар авах зарим арга хэмжээний тухай**

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Төвөөс алслагдсан баруун бүс /Баян-өлгий,Говь-алтай, Завхан, Увс, Ховд аймаг/ нутгийн хүн амын амьжиргааны түвшинг дээшлүүлэх зорилгоор хүн амын орлогын татварыг хөнгөлөх, цалин, тэтгэвэр тэтгэмжид хязгаарын бүсийн нэмэгдэл тогтоох, тус бүс нутагт хөрөнгө оруулж байгаа гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг тодорхой хугацаанд орлогын албан татвараас чөлөөлөх, хөнгөлөх санал боловсруулж энэ оны II улиралд багтаан Засгийн газарт оруулахыг Сангийн сайд Я.Очирсүх, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд С.Сонин нарт даалгасугай.

2.Орон нутгийн хотуудын "Нийтийн аж ахуйг хөгжүүлэх төсөл"-өөр усан хангамжийн төвлөрсөн системийг шинэчлэх, өргөтгөх, ус түгээх цэгийн тоог нэмэгдүүлэх, тоолууржуулах, цэвэрлэх байгууламжийг шүүрүүлэх талбайгаар солих, хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх хямд төсөр технологи нэвтрүүлэх, халуун усыг шинэ технологид шилжүүлэх үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийг олж санхүүжүүлэх арга хэмжээ авахыг холбогдох аймгийн Засаг дарга нарт даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд Р.АМАРЖАРГАЛ

Сангийн сайд Я.ОЧИРСҮХ

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2000 оны 3 дугаар сарын 13-ны өдөр | Дугаар 02 | Улаанбаатар хот

**Шүүхийн тухай хууль, ИХШХШ хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын хуулиудын холбогдох заалтууд, эдгээрийг хэрэгжүүлэхээр гарсан Ерөнхийлөгчийн зарлигууд Монгол Улсын Үндсэн хуулийн зарим заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцсэн тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцэд маргаан хянан шийдвэрлэх хуралдааныг Цэцийн дарга Н.Жанцан даргалж, Цэцийн гишүүн Ж.Амарсанаа, Ж.Бямбажав, Д.Чилхаажав, Н.Чинбат /илтгэгч/ нарын бүрэлдэхүүнтэй, нарийн бичгийн дарга Б.Цэндээхүү, УИХ-ын итгэмжлэгдсэн төлөөлөгч УИХ-ын гишүүн Д.Хувьтөгөлдөр, УИХ-ын Тамгын газрын ерөнхий нарийн бичгийн даргын нэгдүгээр орлогч Ж.Нарантуяа нарыг оролцуулан Үндсэн хуулийн Цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийж, Шүүхийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг, 25.1 дүгээр зүйл, ИХШХШ хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 1999 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн Монгол Улсын хуулийн 4 дүгээр зүйлийн 4, 5 дахь хэсэгт заасан заалтууд эдгээрийг хэрэгжүүлэхээр гарсан Ерөнхийлөгчийн зарлигууд Монгол Улсын Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 1, 50 дугаар зүйлийн 2, 51 дүгээр зүйлийн 1, 2 дахь заалтуудыг зөрчсөн тухай Ц.Монголоос ирүүлсэн өргөдлийг хянан хэлэлцэв.

Чингэлтэй дүүргийн иргэн Ц.Монгол Цэцэд ирүүлсэн өргөдөлдөө: "Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт заасан "Танхимын тэргүүн шүүгчийг Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн санал болгосноор Монгол Улсын Ерөнхийлөгч 6 жилийн хугацаагаар томилно" гэсэн заалт, мөн хуульд 1995 онд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа 25.1 дүгээр зүйл нэмж "Улсын Дээд шүүхийн танхимын тэргүүн шүүгчийн бүрэн эрх" гэсэн зүйл бий болгосон зэрэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн 51 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан "Улсын Дээд шүүх Ерөнхий шүүгч, шүүгчдээс бүрдэнэ", 51 дүгээр зүйлийн 2-т заасан "Шүүхийн Ерөнхий зөвлөлөөс Улсын Дээд шүүхийн шүүгчдийг Улсын Их Хуралд танилцуулснаар ... Ерөнхийлөгч томилно. Ерөнхий шүүгчийг Улсын Дээд шүүхийн санал болгосноор гишүүдийнх нь дотроос зургаан жилийн хугацаагаар Ерөнхийлөгч томилно" гэсэн заалтуудыг зөрчсөн.

Монгол Улсын Үндсэн хуулиар тогтоосон үзэл баримтлалаар Монгол Улсын Дээд шүүх нь албан тушаалын хувьд Ерөнхий шүүгч, шүүгчдээс бүрдэнэ гэдгийг хоёрдмол утгагүйгээр заасан. Гэтэл Шүүхийн тухай хуульд оруулсан өөрчлөлтөөр эрүү, иргэний хэргийг даргынхаа өмнө хариуцах албан тушаалтан бий болгож, түүнийг Ерөнхий шүүгч өөрөө санал болгон Монгол Улсын Ерөнхийлөгч 6 жилийн хугацаагаар томилохоор заасан явдал нь шүүхийн шүүн таслах ажиллагаанд шүүгчдийн бие даан ажиллах явдлыг үгүй болгож, үнэн чанартаа Ерөнхий шүүгч, түүний саналаар тавигдсан тэргүүн шүүгч гэсэн албан тушаалтнуудад эрх олгожээ. Эдгээр байдал нь албан тушаалтан, иргэд хэн боловч шүүгчдээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй, тийм оролцоогүй шударга шүүхээр шүүлгэх тухай хүний эрхийн олон улсын эрх зүйн баримт бичиг, Үндсэн хуулийн заалт зөрчигдөхөд хүрч байна.

Иймээс Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг, 25.1 дүгээр зүйл, эдгээрийг хэрэгжүүлэхээр гаргасан Ерөнхийлөгчийн зарлигуудыг хянан үзэж хүчингүй болгож өгнө үү" гэжээ.

Мөн иргэн Ц.Монгол Үндсэн хуулийн Цэцэд 1 дүгээр сарын 6-нд ирүүлсэн өргөдөлдөө "Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" 1999 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн Монгол Улсын хуулийн 4 дүгээр зүйлийн 4, 5 дахь хэсгүүдэд заасан заалтууд Монгол Улсын Үндсэн хуульд нийцэхгүй байна. Улсын Дээд шүүхийн шүүгч ... оролцогчдын гомдлоор ба өөрийн санаачилгаар эсэргүүцэл бичих эрхтэй болгожээ... Дээрх заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан "Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана" гэсэн заалт болон мөн зүйлийн 2 дахь хэсэгт заасан "... буюу байгууллагын албан

тушаалтан, иргэн хэн боловч шүүхээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй" гэсэн заалтуудыг тус тус зөрчиж шүүхийн байгууллагын албан тушаалтан болох Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, танхимын тэргүүн шүүгч нараас Дээд шүүхийн шүүгчээс хэрэг хянах үйл ажиллагаанд шууд оролцож, иргэдийн гомдол хүсэлтийн дагуу хэргийг шүүгч өөрийн итгэл үнэмшилд тулгуурлан Улсын Дээд шүүхэд оруулж хэлэлцүүлэх боломжгүй болгожээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн 50 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар давж заалдах болон хяналтын журмаар доод шатны шүүхийн шийдвэрийг хянан үзэх эрх нь Улсын Дээд шүүхийн бүрэн эрхэд хамаарах бөгөөд хэргийг Дээд шүүхэд хянах эсэхийг шүүхийн албан тушаалтанд олгоогүй байна. Дээрх хууль гарснаар Монгол Улсын Дээд шүүхийн шүүгчдийн эрх зүйн байдлыг ялгаатай болгож, эрүүгийн хэргийг хянахад Дээд шүүхийн шүүгч эсэргүүцэл бичих эрхтэй байхад, иргэний хэргийг Дээд шүүхийн бүрэн эрхийн дагуу хянахад Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, танхимын тэргүүн шүүгч бусад шүүгчдээс давуу эрх эдлэхээр тогтоосон нь буруу болжээ. Иймд дээрх хуулийн заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн болохыг тогтоож, эдгээр заалтыг хүчингүй болгож өгөхийг хүсье" гэжээ.

УИХ-ын итгэмжлэгдсэн төлөөлөгч Ж.Нарантуяа Үндсэн хуулийн Цэцэд өгсөн тайлбартаа: "Шүүхийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт Үндсэн хууль зөрчөөгүй гэж үзэж байна. Энэ нь зохион байгуулалтын асуудал тодорхойлсон юм. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хувьд иргэн Ц.Монголоос гаргасан гомдлыг хүлээн зөвшөөрч байна" гэжээ.

Мөн УИХ-ын итгэмжлэгдсэн төлөөлөгч Д.Хувьтөгөлдөр "Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хувьд Үндсэн хууль зөрчөөгүй, Шүүхийн тухай хуулийн хувьд Дээд шүүхийн танхимын тэргүүн шүүгч байгаа нь зохион байгуулалтын шинжтэй зүйл учраас уг хуулийн холбогдох заалт Үндсэн хууль зөрчөөгүй" гэв.

ХЯНАВАЛ:

Иргэн Ц.Монголын өргөдөлд дурьдсан Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг, мөн хуулийн $25^1$ дугаар зүйл нь Монгол Улсын Үндсэн хуулийн тавин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалттай; Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 177 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсгийн "Улсын Дээд шүүхийн танхимын тэргүүн шүүгч" гэсэн заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн дөчинесдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, тавин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалттай зөрчилдөж байна гэж үзэх үндэслэлтэй байна.

**Монгол Улсын Үндсэн хуулийн жаран зургадугаар зүйл, Үндсэн хуулийн Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн гучин хоёрдугаар зүйлийн 2 дахь заалтыг удирдлага болгон ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:**

1. Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг, мөн хуулийн $25^1$ дугаар зүйл нь Монгол Улсын Үндсэн хуулийн тавин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг; Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 177 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсэг, 178 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Улсын Дээд шүүхийн танхимын тэргүүн шүүгч" гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн дөчинесдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, тавин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг тус тус зөрчсөн байна.

2. Энэ дүгнэлтийг Улсын Их Хурлын хаврын чуулган эхэлсэн өдрөөс хойш 15 хоногийн дотор хэлэлцэн хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

ДАРГА Н.ЖАНЦАН

ГИШҮҮД Ж.АМАРСАНАА

Ж.БЯМБАЖАВ

Д.ЧИЛХААЖАВ

Н.ЧИНБАТ

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
**Хаяг: «Төрийн мэдээлэл»** эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв

☎ 329487